

Ховд аймгийн Стандарт хэмжилзвйн дарга, аймгийн ХААЖДҮГ-ын Мал эмнэлгийн албаны дарга, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Үенч сумын ЗДТГ-ын дарга, Үенч сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Зэрэг сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга, Дуут сумын ЗДТГ-ын дарга, Жаргалант сумын ЗДТГ-ын дарга, Чандмань сумын соёлын товийн захирлын гэсэн 9 ажлын байрны сонгон шалгаруулалт явагдлаа. Тус шалгалтанд нийт 60 хvн оролцсоноос 54 нь тэнцжээ. Төрийн албаны шалгалтанд оролцогчид ийм ондор vзvvлэлттэй тэнцэж байсан тохиолдол ховор юм.

Шалгалтыг цахимаар биш уламжлалт хэлбэрээр авсан нь vвнд нолоолсон бололтой.

Ихэвчлэн одоогоор төрийн байгууллагад ажиллаж байгаа хараахан шалгалтандаа орж тэнцээгvй байсан хvмvvс энэ шалгалтанд орсон ба төрийн албаны албан тушаалын ТЗ-7, ТЗ-5, ТЗ-6 гэсэн ангиллаар нооцод шууд бүртгэгдэх юм байна. Харин олно нь буюу 9 сард цахимаар шалгалтанд ороод тэнцээгvй 300 гаруй хvний хувьд дахин шалгалтанд орж төрийн албанд ажилд орно гэдэг найдлага талаар болж байгаа бололтой. Дашрамд дурдахад шалгалтын комиссийн бүрэлдэхvвний зvгээс энэ удаагийн шалгалтыг олнох 9 сард явагдсан цахим шалгалтыг бодвол харьцангуй хялбар байдлаар дvгнэгдсэн хэмээн онцлож байсан. Оролцогчдын дийлэнх нь тэнцсэн ч гэлээ энэ шалгалттай холбоотой санал гомдол нэлээд байна. Тухайлбал, шалгалтын талаар мэдээлэл хомс байсан тодийгvй зарим иргэдийг бүртгэхгvй буцааж нэг vгээр бол ялгавартай хандаж байсан гэгцгээж байгаа юм.

Ж.Саруул

